



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 едөр

Дугаар 627

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 он, 2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалт, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр нийт 1,211.88 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

2.1.Компаниас татаас санхүүжилт, дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэх талаар Сангийн яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлсэн саналыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдлагаар ханган ажиллах;

2.2.“Багануур ус” ОНӨҮГ-тай байгуулсан аж ахуйн гэрээ, шугамын түрээсийн гэрээнд хяналт тавьж, шимтгэлийн зардал, түрээсийн үнэлгээний хувь хэмжээг үндэслэлтэй тогтоосон эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулах;

2.3.“Хөх чоно групп” ХХК-тай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээнээс компанийд их хэмжээний хөрөнгө, санхүүгийн эрсдэл үүсэх нөхцөл байдал үүссэнийг анхаарч хяналт тавьж ажиллах.

3.“Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Ганбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.Санхүүгийн хүндрэлийг даван туулахад шаардлагатай татаас санхүүжилт, дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэх, төсвийн өр төлбөрийг үе шаттайгаар барагдуулах асуудлаар холбогдох байгууллагуудад тооцоо судалгаа, тодорхой үндэслэл бүхий мэдээлэл, хүсэлт хүргүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

3.3.“Хөх чоно групп” ХХК-тай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн үндэслэл нь хууль тогтоомж, журамд нийцсэн эсэх, тус компаниас хийсэн гэх 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, гэрээ хэрэгжих хугацаанд хөрөнгө оруулагч талаас гаргасан зардал нь тухайн байгууллагын санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдан, татвар, Аудитын байгууллагаар баталгаажуулсан

132007048

\Huraldaanii material\2021 он\2021.12.14 22-r huraldaan.docx

эсэхийг анхан шатны баримт, нотолгоонд тулгуурлан бодитой тогтоосон эсэхийг мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагаар шалгуулах;

3.4.Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа зардал, орлогын бодит эх үүсвэрт нь тулгуурлах, З талт хамтын хэлэлцээр (гэрээ)-т компанийн бодит боломжоос давсан зүйл, заалт оруулах, тэтгэмж, тусламжийг хавтгайруулан олгох асуудлыг таслан зогсоох;

3.5.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авч эргэлтийн хөрөнгө, зардлаар бүртгэдэг зөрчлийг давтан гаргахгүй байх, эргэлтийн хөрөнгө, зардалд бүртгэсэн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авсны үндсэн дээр хөрөнгөд бүртгэх, хяналт тавьж ажиллах;

3.6.Компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлал гаргаж мөрдүүлэх тухай Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

3.7.Төрийн өмчийн байр талбай, тоног төхөөрөмжийг бусдад ашиглуулах, түрээсийн үйл ажиллагааг эрхлэхдээ эрх бүхий байгууллагаас баталж мөрдөхөөр заасан журмыг баримтлан ажиллах;

3.8.Компанийн эзэмшилд байгаа Багануур дүүргийн 1 дүгээр хороонд байрлах, дамжуулах төвийн байгууламжийн зориулалттай, 140.0 м.кв талбай бүхий газар, мөн 3 дугаар хороонд байрлах, орон сууцны зориулалттай, 1000.0 м.кв талбай бүхий газрыг Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолын дагуу үнэлж, санхүүгийн тайланд тусгах;

3.9.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмыг мөрдөн ажиллах;

3.10.Дулаан борлуулалтын болон бусад авлага барагдуулах зориулалтаар шүүхийн шийдвэрийн дагуу бусдаас хүлээн авсан эд хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг үндэслэн, хууль тогтоомжид заасны дагуу худалдан борлуулах, захиран зарцуулах;

3.11.Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1 жил ба түүнээс дээш хугацаатай авлагыг барагдуулах, цаашид найдваргүй авлага үүсгэхгүй ажиллах;

3.12.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, давтан гаргасан ажилтан, албан тушаалтанд хууль, журмын дагуу тухай бүр хариуцлага тооцох.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний
өдрийн ~~227~~ дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая.төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Батлагдсан төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлсэн, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үргүй зардал санхүүжүүлсэн.	249.28	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсгийг мөрдөн ажиллах.
2	2019 он, 2020 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханганд биелүүлээгүй.	-	Компанийн тухай хуулийн 76.1.9, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах.
3	2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авч тайлант жилийн зардаар бүртгэсэн. Хөрөнгийн ангилал шилжүүлэхдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрөл аваагүй.	121.8	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах шилжүүлэх журам"-ыг мөрдөн ажиллах.
4	Компанийн эзэмшлийн 2 ширхэг, 1140.0 м ² газрыг үнэлж санхүүгийн тайландаа тусгаагүй.	-	Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай 10 дугаар тогтоолын 4 дэх хэсгийг үндэслэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж бүртгэх.
5	Дулаан борлуулалтын авлага барагдуулах зориулалт бүхий орон сууцыг худалдан борлуулсан, төлбөр тооцоог хугацаанд нь барагдуулаагүй.	2.0	Шүүхийн шийдвэрийн дагуу бусдаас хүлээн авсан эд хөрөнгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг үндэслэн, хууль тогтоомжид заасны дагуу худалдан борлуулах, захиран зарцуулах.
6	Худалдан авах ажиллагаанд техникийн тодорхойлолтыг хууль журмын дагуу боловсруулаагүй. Зарим худалдан авалтыг цахим системд байршуулаагүй, үр ашигтай төлөвлөж зохион байгуулаагүй.	838.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмуудын хэрэгжилтийг ханганд ажиллах.
7	Дулаан эрчим хүчээр хангах, хэрэглэх аж ахуйн гэрээ, шугамын түрээсийн гэрээнүүдийн хууль эрх зүйн үндэслэл, төлбөр хураамж, Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулах асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах.	-	Компанийн тухай хуулийн 76.1.17, 76.1.18 дугаар заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.
	Нийт дүн:	1,211.88	(Нэг тэрбум гурван зуун хорин найман сая дөрвөн зуун жаран мянган төгрөг)
		1140 м ² газар	